


Living the LOTUS

Buddhism in Everyday Life



2
2019

VOL. 161

Үүсгэн байгуулагчийн сургаал

Шударга үнэнээр амьдрах

Чин сэтгэлээсээ итгэж чадах хүн ганц ч болов байвал тэр хүн амьдралдаа том амжилт гаргажээ гэж хэлж болох болов уу. Шашин шүтлэг нь үүний төлөө л оршин тогтнодог. Учир нь Бурхан багш бүгдийг харж байгаа гэж итгэх нь шашин шүтлэгийн хамгийн том буян гэж би боддог.

Энгийн хүмүүс бусдад мэдэгдэхгүй л бол бага зэргийн заль мэх гаргахад гэмгүй гэж бодож магадгүй. Харин сэтгэлдээ бурханыг үргэлж тээдэг хүн бол зуун хувь шударга үнэнчээр явахаас өөр замгүй. Жаахан заль мэх гаргаж, өөрт ашигтай зүйлийг хийе гэж чадахгүй болно гэсэн үг.

Харин сайн зүйл хийхэд хэн ч харахгүй бай, хэн ч ойлгож, дэмжихгүй бай, Бурхан тэнгэр харж байгаа гэж бодоод, хичээл зүтгэлээ зогсоолгүй, бүгдийг бурханд даатгаж чадвал сэтгэл хоёрдох зүйлгүй болно.

Өдийг хүртэлх амьдралаа эргэн харахад миний олж авсан хамгийн том аз жаргал бол Бурханд бүрэн итгэж, ямарч эргэлзэх зүйлгүйгээр өнөөдрийг хүртэл амьдарч ирсэн явдал яах аргагүй мөн. Түүний ачаар л уулзаж, учирсан хүн бүртээ ямарч санаа зовох зүйлгүйгээр итгэж чадсан юм.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.190-191

Living the Lotus Vol. 161 (2019.02)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Ж.Гэрэлтуяа

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Бусдыг бодох “сэтгэлийн дадал”

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Ашиг хонжоо нь буянтай ижил утгатай

Гудамжинд тэвдэж сандарсан хүнтэй тааралдахад та бүхэн яадаг вэ? Дөхөж очоод юу тохиолдсныг асуух хүн цөөнгүй байна гэж бодож байна. Нөгөөтэйгүүр яасан юм бол доо хэмээн дотроо бодсон ч “миний оролцох хэрэг биш байх” гээд холдон одох хүн ч байх болов уу. Бүх хүн тийм биш байж магадгүй ч, хүмүүс бид аливаа зүйлийг ашигтай ашиггүй гэсэн үнэлэмжээр цэгнээд, ашиггүй гэж үзсэн зүйлээсээ зайгаа барих хандлагатай байдаг. Хүмүүс бид энэхүү тооцоотой хандлагаасаа салах тийм ч амаргүй.

Сүүлийн үед хэрэгт орооцолдож, хам хэрэгтэн болж магадгүй тул огт танихгүй хүнтэй юм ярих нь ямар ч ашиггүй зүйл гэсэн ойлголт бий болсон. Гэхдээ үнэхээр тийм гэж үү?

Ашигтай ашиггүйн “ашиг хонжоотой” нь “буян” гэсэн үгтэй ижил утгатай гэсэн тайлбар байдаг. Нэг төгрөгний ашиггүй байж болох зүйл дээр ч бусдын сайн сайхны төлөө бодож хийсэн үйл нь тэр хүндээ сэтгэлийн буян болж, хүнийхээ хувьд өсөж хөгжих үнэ цэнэтэй сэтгэлийн хөрөнгө болох нь гарцаагүй. Хүнийхээ хувьд өсөж хөгжихийг хүсэх нь хүн чанарын дэвшил хэмээх “буян”-ыг даллан дуудах гэсэн утгаараа “ашиг хонжоотой” гэдэг үг нь “буян” гэсэн утгатай ижил юм.

Дээрх ойлголтыг мэдэж байгаа ч сандарч, тэвдсэн хүнийг хараад “энэ хүнд туслахсан” гэсэн хүслээ бодот үйл болгох алхамыг хийхэд зориг нь хүрдэггүй хүн байдаг.

Хэмжээлшгүй Утгасын Сударт “энэрэхүйн сэтгэлийг үүсгэж, их нигүүлсэхүйг төрүүлээд, магад аврал одуулсугай хэмээн бас дахин хамаг номд гүнээ орогтун.” (орч.Болдбаатар.Т УБ.,(2012), “Адмон принт” хэвлэл, 22 тал) (Ном номлохуйг үгүүлэхүй 2-р бүлэг) гэсэн хэсэг байдаг. Энэ хэсэг нь Бодисадва нарт “эргэн тойрны хүмүүсээ өрөвдөн энэрч, тэдний төлөө бодох сэтгэлийг бий болгож, <зовлон шаналалаас нь аварья> гэж шийдэхтун” гэдгийг сургасан нэг мөрт юм. Үүний тулд “хувиа хичээсэн аминч үзэл, шуналаасаа салж, аливаа зүйлийн жинхэнэ мөн чанарыг олж харахын төлөө хичээх нь чухал” гэдгийг сургасан байгаа юм.

Өөрөөр хэлбэл ашигтай, ашиггүй хэмээн аливаад тооцоотой ханддаг хандлагаа хаяж чаддаггүй бид хичээх юм бол шуналын сэтгэлээ давж, тэр нь сэтгэлийн дадал болвол ямар ч үед ашигтай ашиггүй хэмээх тооцоотой хандлагадаа удирдуулахгүйгээр бусдын төлөө бодсон сэтгэл үүсэх үед даруй түүнийгээ үйлдэл болгон гаргаж чадна гэсэн үг юм.





Бүх зүйл нэгэн бүхэл

*Балчир үрээ алдсан эх
цас орох үед*

даарах вий, бээрэх вий гэж

булшин дээр нь шүхэр барин зогсоно

Энэ шүлэгнээс үрээ алдсан эхийн өр эмтрэм сэтгэл мэдрэгдэж байна. Мөн бодисадва хүн бусдын сайн сайхны төлөө бодно гэдэг ийм л сэтгэлийг хэлэх болов уу гэж санагдана.

Шүлэгт гарах эх бурхан болсон хүүхдээ дурсан санаж, бие сэтгэлээрээ үргэлж цугтаа байж, даарч байна, хүйтэн байна хэмээх далд дуу хоолойг сонсож, оргилон гарч ирсэн сэтгэлээ үйлдэл болгосон болов уу гэж бодогдоно. Эндээс бодисадвагийн нигүүлсэнгүй сэтгэлийг олж харж байгаа нь би ганцаараа биш байхаа.

Дээр дурьдсан “хувиа хичээсэн аминч үзэл, шуналаасаа салж, аливаа зүйлийн жинхэнэ мөн чанарыг олж харах” гэдэг нь дээрх эх шиг нөгөө хүнтэйгээ өөрийгөө нэгэн бүхэл гэж харахыг хэлэх болов уу. Улмаар бүх зүйлийг нэгэн бүхэл гэж хардаг болвол бусдын баяр хөөр, уйтгар гунигийг ч сайн ойлгодог болж, үүнээс урган гарсан өрөвдөн энэрэх сэтгэл, нигүүлсэх сэтгэл өөрийн эрхгүй төрж, бусдыг бодох сэтгэлээ үйлдэл болгож чаддаг.

“Бүх зүйл нэгэн бүхэл” гэсэн үзэл нь бусдыг бодох сэтгэлийг “дадал” болгох үндэс юм.

Дээр үед үүсгэн байгуулагчийн мэндэлсэн Нийгата мужийн Тоокамачи хотод очих үеэр, цэцэрлэгт хүрээлэнд залрах үүсгэн байгуулагчийн цээж баримал бороонд хорохыг хараад миний бие ч гэсэн өөрийн эцэг мөн багшийнхаа хөшөөнд шүхэр дэлгэн борооноос хамгаалсан удаа бий. Миний бие хойшид ч ямарч үед, хэнд ч ижилхэн сайн сайхныг хүсэн хандаж чаддаг хүн болохын төлөө хичээх болно.

Зэн урсгалын их мастер Шидо Бүнан 1603)–76 он): “Ямарч хүчлэл, зүтгэлгүйгээр нигүүлсэнгүй сэтгэл төрөн гарч байвал түүнийг бурхан будда хэмээн нэрлэмүй” гэж сургасан байдаг. Бусад хүмүүстэй нэгэн бүхэл болж чадвал энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэлээр хандая гэж бодохгүй байсан ч бусдыг бодох сэтгэл тань таныг болон бусдыг хөгжүүлэх үндэс болно.

“Косей” сэтгүүл 2-р сарын дугаараас



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Сүслэн авахуйг үгүүлэх 4-р бүлэг

Хичнээн Бурханаас нүүраа буруулсан ч

Энэхүү баян ноён бол яриангүй Бурхан. Харин гэрээсээ дайжсан хүү бол хүмүүс бид билээ. Бид бүхэн ямарч эргэлзээгүй бурханы хүүхдүүд атлаа түүнийгээ ухаардаггүйгээсээ бурханаас ийнхүү өөрсдөө нүүр буруулж орхидог. Гэхдээ эцэг эх, үр хүүхдийн харилцаа гэдэг хүчирхэг зүйл бөгөөд өөрийгөө бурханы хүүхэд (бурханлаг чанартай) гэдгээ мэдэхгүй байсан ч хэзээ нэгэн цагт бурханы байгаа зүг лүү чиглэдэг ажээ. Энэ бол хүний мөн чанар (бурханлаг чанар)-ын илрэл гэж хэлж болох бөгөөд үнэхээр талархмаар чанар юм.

Хүмүүс бурханы хаалганы өмнө зогссон ч бурханыг өөрийн эцэг гэдгийг мэддэггүй бол Бурхан харин биднийг өөрийн хүүхэд гэж ямагт таньж байдаг. Энэ хэсэг их чухал утгатай. Сансар огторгуйн их амь нас гэж хэлж болох Ялж Төгс Нөгчсөн Язгуурын бурхан нь үргэлж бидний бие сэтгэлийн дотор, гадна оршиж байдаг атал бид түүнийг анзаардаггүй. Язгуурын бурхан биднийг анзаарахыг хүлээж байдаг. Үнэн ном үргэлж олонд танигдаж, ил болохоо хүлээж байдаг гэсэн үг юм.

Өөрийн бурханлаг чанараа мэддэггүй хүмүүс

Түүхэн хүн болох Шагжамүни нь хорвоод мэндэлж, Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Бурхан болоод хүмүүс угтаа бол нэгэн бүхэл юм гэдгийг ойлгуулахыг хичээх боловч тэрхүү сургаал хэтэрхий гүн гүнзгий байсан учраас хүмүүс над шиг энгийн хүмүүс дөхөж очих түвшин биш байна гэсэн өөрийгөө голсон бодлоосоо ангирч чадалгүй, эмээснээсээ болоод тэрхүү сургаалын хаалганы өмнөөс зугтаж орхидог.

Бурхан тэр үед уран арга хэрэглэж, хүмүүстэй ижилхэн дүрд хувилах бөгөөд энгийн хүмүүсээс сургаалыг ойлгох түвшин арай илүү 2 эрийг сонгож туслалцаа авна. Тэдгээр хүмүүс нь бурханы орд харшийн доод хэсэгт ажиллаж, сэтгэлийн амар амгаланг олсон

хүн (Ширваган, брадэдигабуддагийн түвшинд хүрсэн хүмүүс) бөгөөд хүмүүст энэ бол нөхөрлөж болохоор хүн байна гэсэн сэтгэлийг үүсгэн, орд харшийнхаа доод давхарт ажиллуулдаг. Эндээс Бурхан багш биднийг хэзээ ч орхилгүй, ямар нэгэн аргаар бидний дотор орших бурханлаг чанараа анзаараасай хэмээн янз бүрийн арга хэрэглэж байдаг гэдгийг тодорхой мэдэж болно.

Доод түвшин ч гэсэн чухал

Ийнхүү бохир зүйлийг цэвэрлэх ажлыг хийлгэдэг. Үүний цаад зорилго нь сэтгэлийн төөрөгдөлөөс нь ангижруулах явдал байв.

Бурхан иймэрхүү үйлээр дамжуулж, хүмүүсийг аажмаар бурханы сургаалд ойртуулан дасгасны дараа “чамайг өөрийнхөө хүүхэд болгоё” гээд өөртэйгөө ижил түвшин хүртэл татан гаргахыг хичээх боловч хүүхэд нь хараахан бурханы түвшинд хүрч чадна гэсэн итгэлгүйн дээр хэтэрхий өндөр түвшин хэмээн бодсоны улмаас биед амар доод түвшиндээ тухлангаа урт хугацааны туршид бага багаар үйлийг үргэлжлүүлэхийг илүүд үзнэ. Энэ хэсэг ч гэсэн анзааралгүй өнгөрүүлж боломгүй хэсэг юм. Бурханы түвшинийг ойлгох чадварыг





эзэмшихийн тулд таарч тохирсон үйлийг тасралтгүй хийх шаардлагатай гэдгийг илэрхийлсэн байна.

Ингэж байх хугацаанд хүмүүс бурханы сургаалыг сайн ойлгох болж, аажмаар сэтгэлийн амар амгаланд хүрэв. Тэр үед нь хөрөнгө захирах эрх мэдлийг олгоод сургаалын сангаа бүхэлд нь даатгасан байна.

Гэхдээ хүмүүс бурханы сургаалыг бусдад түгээх хүндтэй үүргийг гүйцэтгэж байгаа хэрнээ бурханы жинхэнэ хүүхэд гэдгээ огт төсөөлөхгүй байлаа. Өөрөөр хэлбэл өөрийн мөн чанар бурхантай ижил гэдгийг огтхон ч анзаарахгүй, бурхан бол эзэн харин би бол боол гэж бодоод бурхан болон өөрийнхөө дундуур шугам татан зааглан боддог байв.

Бурханлаг чанараа олж нээх нь

Бурхан насан эцэслэхийнхээ өмнө Цагаан Лянхуан Сургаалыг айлдан, “бурхан болоод хүмүүсийн хооронд зааг гэж байхгүй. Эзэн болоод боол хэмээх ялгаа ч байхгүй. Анхнаасаа л эцэг хүү байсан. Тиймээс хэн ч байсан бурханы бүх хөрөнгийг өвлөн авах боломжтой. Өөрөөр хэлбэл бүх хүн бурхантай ижил түвшинд хүрэх боломжтой” гэж нээлттэй тунхагладаг.

Энэ үед л анх удаа хүмүүс бурханы сургаалын жинхэнэ утгыг ойлгож, санаанд ч оромгүй хөрөнгө (бурханы гэгээрэл)-ийг баттай өөрийн зүйл болно гэдгийг мэдээд ихээр баярладаг.

Өөрийн мөн чанарын үнэ энийг мэдэх нь

Энэ үлгэрт гарч байгаа санааг товчлоод хэлвэл “өөрийгөө төөрөлдсөн хүн, нүгэл ихтэй хүүхэд гэх зэрэг сөрөг, өөрийгөө голсон үзлээ хаяад, бурханы хүүхэд хэмээх үнэнийг ухаараасай” гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл “өөрийн мөн чанарынхаа үнэ цэнийг олж нээцгээе” гэсэн санааг илэрхийлж байна.

Ингэж ухаарч чадвал болчимгүй үйлдэл хийж чадахгүй болно. Төөрөгдөл хэмээх сэтгэлийн гэм үүссэн ч бай, түүнд захирагдан, алдаж, зовж шаналах зүйл байхгүй болно. Шуналын сэтгэл төрсөн ч цаанаасаа л сайн зүг лүү чиглүүлэн ашиглах болно. Энэ нь өөрөө



маш том аврал буян юм.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 63-68

“Бусдыг бодох”-ыг сэтгэлийн дадал болгох нь

“Өвлийн хамгийн хүйтэн үеийн номын уншлага” хараахан дуусаагүй байна. Энэхүү уламжлалт уншлагыг дуусмагц жил шинээр эхэлж буй мэт сэтгэгдэл төрдөг хүн цөөнгүй бизээ.

Энэ жил Нивано ерөнхийлөгч сар бүрийн сургаал дээрээ “Лянхуан гурамсан судар”-аас иш татаж, тайлбарлаж байна. 2-р сард Хэмжээлшгүй Утгасын Судраас иш татсан байна. *Энэрэхүйн сэтгэлийг үүсгэж, их нигүүлсэхүйг төрүүлээд, магад аврал одуулсугай хэмээн бас дахин хамаг номд гүнээ орогтун.*” (орч.Болдбаатар.Т УБ.,(2012), “Адмон принт” хэвлэл, Х.22). Энэ хэсэг нь “эргэн тойрны хүмүүсээ өрөвдөн энэрч, тэдний төлөө бодох сэтгэлийг бий болгож, <зовлон шаналалаас нь аваръя> гэж шийдэхтун” гэдгийг Бурхан багш Бодисадва нарт хандан айлдсан хэсэг билээ.


Ийм сэтгэлийг өөртөө дадуулахын тулд эх хүн хүүхдээ ямарч хариу нөхцөлгүйгээр хайрлан, авралын гараа сунгадаг шиг бусад хүмүүсийг өөр шигээ бодох чухал. Улмаар “бүх зүйл нэгэн бүхэл” гэж харснаар “бусдыг бодох сэтгэл”-ийг сэтгэлийнхээ дадал болгох хэрэгтэй хэмээн ерөнхийлөгч маань айлдсан байна.

Энэ сард бусдыг бодох үйлийг хэрэгжүүлэхийг өөрийн зорилтоо болгон хичээх болно.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224
 e-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
 e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
 e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
 P.O. Box 692148, San Antonio, TX 78269, U.S.A.
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
 e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
 Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
 e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740 U.S.A.
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
 e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
 e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
 Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
 e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
 Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
<http://rkchi.org/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303
 e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
 Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
 CEP 04116-060 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377 Fax: 55-11-5549-4304
 e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
 CEP 08730-000 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100, Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701, Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,
Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibrk.or.jp/>

Branches under the Headquarters**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of South Asia Division**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division**Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu,
Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna**Rissho Kosei-kai of Singapore****Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel & Fax: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station:
Mirshari, District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar,
Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu**Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Branches under the Headquarters****Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax: 39-06-48913949 e-mail: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris**